# “ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН 2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2026 оны 02 сарын 02 ны өдөр | Хэрлэн сум

| № | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хариуцах эзэн | Хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| | **Зорилт 1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх** | | | | | |
| 1. | 1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн зурагт хуудас, гарын авлагыг а/компанийн албан ёсны цахим хуудас; б/компанийн цех, алба нэгжүүдийн мэдээлэл сурталчилгааны самбар болон харагдахуйц хэсэгт байршуулах зэрэг боломжтой хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх; | а/Алба,нэгжүүдийг хамруулсан байх<br>б/Баримтжуулах | -Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн мэдээ, мэдээллийг тухай бүр нь байршуулж тайланд нотломжийг хавсаргасан байна.<br>-Цахим хуудаст мэдээллийг оруулсан байна. | -Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн ХХХ-ийн мэргэжилтэн<br>-Техникийн бодлогын хэлтсийн Мэдээллийн аюулгүй байдал,сүлжээний инженер | Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн зурагт хуудас, гарын авлагыг Компанийн “авлигын эсрэг хамтдаа” мэдээллийн самбар болон цех, алба нэгжүүдийн харагдахуйц газар байршуулсан.<br>Мөн “Авлигаас урьдчилсан сэргийлэхэд таны оролцоо чухал”, “Авлига хүнд суртлыг 110 дугаарт мэдэгдэе”, “Авлигад үгүй гэж хэлцгээе” зэрэг уриатай богино хэмжээний контент бэлдэж, компанийн цахим хуудас www.ees.energy.mn –д байршуулсан болно. |
| 2. | 1.2.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах ”Авлигын эсрэг хамтдаа (Шударга ёс, хөгжил дэвшилд 110)” мэдээллийн самбарын ажлыг тогтмолжуулах | а/Самбарын мэдээллийг Алба, нэгжүүд зурагт хуудас болон бусад хэлбэрээр баяжуулах | -Мэдээлийн самбарын байршлыг ажилтнуудад харагдахуйц газар болгох;<br>-Нотломж хавсаргах; | -Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн ХХХ-ийн мэргэжилтэн<br>-Цех, алба, нэгжийн удирдлагууд | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах ”Авлигын эсрэг хамтдаа (Шударга ёс, хөгжил дэвшилд 110)” мэдээллийн самбарт 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн зурагт хуудас, гарын авлагыг тогтмол байшуулан ажиллаж байна. |
| **Зорилт 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх** | | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3. | 2.1.Худалдах, худалдан авах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах арга хэмжээ авах | а/Байгуулсан гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгах;<br>б/Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; | -Худалдах, худалдан авах аливаа гэрээ авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор авлигын эрсдэлийг мэдээлэх заалт оруулах;<br>-Нотломж хавсаргах; | -Худалдан авах ажиллагааны хэлтсийн Худалдан авалтын гэрээ хариуцсан мэргэжилтэн | 2025 онд байгуулсан Худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх болон бусад нийт гэрээнд:<br>Нийлүүлэгч тал нь энэхүү гэрээнд заасан ажил үүрэг гүйцэтгэхдээ Захиалагч талын удирдлагын баг болон ажилтан холбогдох албан тушаалтанд мэдэгдэхгүйгээр хувьд нь хөнгөлөлттэй ажил үйлчилгээ амлах, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөхийг хориглоно.<br>Захиалагч нь Нийлүүлэгч талын удирдлагын баг болон ажилтнаас энэхүү гэрээний ажил үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан хөнгөлөлттэй ажил үйлчилгээ, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөхийг шаардсан тохиолдолд үүнийг үйлчлүүлэгч талын эрх бүхий албан тушаалтанд мэдээлэх үүрэгтэй гэх заалтуудыг тус тус тусгаж оруулсан байна. |
| 4. | 2.2.Байгууллагын цахим хуудсанд дүн шинжилгээ хийж, мэдээллийг ил тод байдлыг хангаж ажиллах; | а/ Засгийн газрын 2022 оны 353 дугаар тогтоолыг баримталсан байх;<br>б/ Байршуулбал зохих мэдээллийн тоо | - Мэдээлбэл зохих бүх мэдээллийг байршуулж ажиллана. | - Техникийн бодлогын хэлтсийн ахлах инженер | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн дагуу 51 төрлийн нээлттэй мэдээллийг тухай бүр нь байгууллагын https://ees.energy.mn, shilendans.gov.mn сайт дээр бүрэн бүтэн, ил тод байршуулж, тайланг улирал бүр Засгийн газрын https://shilen.gov.mn цахим хуудаст тайлагнаж байна. |
| 5. | 2.3.Компанийн төсөв, санхүүгийн талаарх мэдээллийг ил тод, нээлттэй байлгах; | а/Нийтийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтыг баримталсан байх; | - Shilendans.gov.mn-д байршуулбал зохих бүх мэдээллийг үнэн, зөв байршуулж ажиллана.<br><br>-Нотломж хавсаргах; | - Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга | Ил тод нээлттэй байх бүх мэдээллийг зохих хугацаанд байршуулсан. Нийт 157 мэдээллийн төрлийг 2025 оны 1-12 сарын 2445 гүйлгээний мэдээлэл зэргийг тухай бүр https://shilendans.gov.mn/organization-д Байршуулах ажил тогтмолжсон байна. |
| **Зорилт 3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6. | 3.1.Компанийн худалдан авах ажиллагааг өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, нээлттэй байлгах; | а/Нийтийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтыг баримталсан байх; | - Shilendans.gov.mn-д 2025 оны худалдан авалтын төлөвлөгөөг зохих журмын дагуу байршуулж ажиллана.<br>- Нотломж хавсаргах; | - Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга | - Shilendans.gov.mn-д 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны дотор тус тус оруулсан.<br>- Мөн сар бүрийн 07-ний дотор өмнөх сард байгуулсан гэрээ болон тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн ашиг сонирхлын мэдүүлэгийг оруулж хэвшсэн байна. 2025 онд нийт 112 гэрээ шилэн дансанд байршуулж ажиллалаа. |
| 7. | 3.2.Худалдан авах ажиллагааны үр дүнг ил тод байлгах; | а/Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримталсан байх; | -Tender.gov.mn-д байршуулбал зохих мэдээллийг үнэн, зөв байршуулж ажиллана.<br>-Нотломж хавсаргах; | - Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга | 2025 оны 01 дүгээр сарын 29-нд батлагдсан Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нийт 104 ажлыг Tender.gov.mn-д байршуулан бүртгэж, үүнээс 62 ажилд тендер зарлан хугацаанд нь амжилттай шалгаруулж, үр дүнг хугацаанд нь оруулсан.<br>Мөн тендертэй болон шууд худалдан авалтаар хийгдсэн 95 гэрээ болон гэрээ дүгнэсэн актыг Tender.gov.mn-д байршуулж ил тод болгон ажиллаж байна. |
| 8. | 3.3.Нийтийн албан тушаалтнуудад Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсээс цахимаар сургалт авах; | а/ “Авлигын ойлголт, шалтгаан, хор хөнөөл, авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа”<br>б/ “Ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх асуудал” сэдэвт сургалт авах | - Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан тай холбогдож, сургалтыг авах<br><br>-Нотломж хавсаргах; | -Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн XXX-ийн мэргэжилтэн | Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсээс зохион байгуулсан Авлигын ойлголт, шалтгаан хор хөнөөл, авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх асуудал сэдэвт сургалтанд 2025 оны 02 дугаар сарын 02 ны өдөр эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулж ажилласан.<br>Мөн Эрчим хүчний яамны Гэрээ, эрх зүйн газар Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтанд 2025 оны 09 дүгээр сарын 19 ны өдөр эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулж ажиллалаа. |

Хавсралт 1

Авлигын ойлголт, шалтгаан хор хөнөөл, авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх сургалтанд хамрагдсан байдал



Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсээс эрчим хүчний салбарын зарим ТӨХК-ийн албан тушаалтнуудыг авлигын эсрэг сургалтад хамруулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулж байна.

***Энэ удаагийн цахим сургалтад:***

**“Дорнод бүсийн эрчим хүчний станц” ТӨХК-ийн** ажилтан, албан тушаалтнуудыг хамруулан 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 10:00-11:00 цагт зохион байгуулах тул холбогдох арга хэмжээг авч ажиллана уу.

-***Сургалтын агуулга, сургалт хийх албан хаагчийн нэр:***

- **Авлигын ойлголт, шалтгаан, хор хөнөөл, авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа**
*Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Г.Ариунзаяа*
- **Ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх асуудал**
*Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар У.Номин-Эрдэнэ*

***- Сургалтын бүртгэлийн холбоос:***
***https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSd70k7-mW1VzOliV7y_VYGUmvWI0YxHSRNHDIsc4oFca-GjUQ/viewform***

***- Zoom холбоос:***
Topic: Эрчим хүчний салбарын зарим ТӨХК-ийн албан тушаалтнуудад зориулсан сургалт
Time: Feb 12, 2025 10:00 AM Irkutsk, Ulaanbaatar
Join Zoom Meeting
***https://us06web.zoom.us/j/7139870340?pwd=EBbEraiarVUuyNPyaWt3JokhqCfwLK.1&omn=88198285898***
Meeting ID: 713 987 0340
Passcode: 110





**АТГ-аас цахим сургалтын талаар**

Сайн байна уу, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем https://meduuleg.iaac.mn/ шинэчлэгдэж буйтай холбогдуулан шинэ системийн талаар сургалтыг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр 09 цагт зохион байгуулах гэж байна. Иймд та бүхэн сургалтад идэвхтэй оролцоно уу. Дараах холбоосоор сургалтад оролцоно уу.

Topic: Цахим системийн сургалт
Time: Dec 1, 2025 09:00 Ulaanbaatar
Join Zoom Meeting
https://us06web.zoom.us/j/85200583227?pwd=F3eOuwUeNkOzJxYmf0CgWVgUIHVZbO.1

Meeting ID: 852 0058 3227
Passcode: 110

Хүндэтгэсэн,

Г.Энхжин



**АТГ-ААС ЗОХИОН ЯВУУЛСАН ХУВИЙН АШИГ СОНИРХОЛЫН МЭДҮҮЛЭГ, ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛИЙН СУРГАЛТАД СҮХБААТАР ЦТС САЛБАРААС ХАМРАГДСАН АЖИЛТНЫ НЭРСИЙН ЖАГСААЛТ**

2025.12.01

| Д/д | Ажилтаны нэр | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|
| 1 | Р.Эрдэнэцогт | Салбарын дарга | |
| 2 | С.Сайнзаяа | СХ Ерөнхий инженер | |
| 3 | Э.Октябрь | Ахлах нягтлан бодогч | |



**АТГ-аас 2025 оны 12 дугаар сарын 01 ний өдөр зохион байгуулах цахим сургалтанд хамрагдах ажилтнуудын жагсаалт**

11/28/2025

| | Албан тушаал | Овог нэр | Гарын үсэг |
|---|---|---|---|
| 1 | Гүйцэтгэх захирал | Ө.Жаргалсайхан | |
| 2 | Ерөнхий инженер | Я.Наранбаатар | |
| 3 | Дотоод аудитор | Г.Ганбүргэд | |
| 4 | Маркетинг, ил тод байдал хариуцсан менежер | Т.Төмөрбаатар | |
| 5 | Хяналт хариуцсан менежер | Д.Гүнсмаа | |
| 6 | Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга | Т.Оюун | |
| 7 | Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч | Б.Энхбаатар | |
| 8 | Хяналт, аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга | Н.Баасанпүрэв | |
| 9 | Нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга | Ч.Одбаяр | |
| 10 | Техникийн бодлогын хэлтсийн ахлах инженер | Э.Ганзориг | |
| 11 | Үйлдвэрлэл, шуурхай ажиллагааны албаны дарга | Ө.Од | |
| 12 | Ахлах нягтлан бодогч | Д.Мөнхбаяр | |
| 13 | ДШС цехийн дарга | Ж.Гантулга | |
| 14 | ЦШС цехийн дарга | М.Цоггэрэл | |

*Жич: Цахим сургалтанд хамрагдах ID, pass хавсаргав.*

ЭБАТ Н.ОДГЭРЭЛ

Хавсралт 2

Компанийн цахим хаягт нээлттэй мэдээлэлд байршуулсан байдал






Хавсралт 3

## Худалдах худалдан авах гэрээнд авлигын эсрэг заалт оруулсан байдал



БАТЛАВ
"ДБЭХС" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЖАРГАЛСАЙХАН

БАТЛАВ
"БАЯН БАЯДЫН ЗАЛУУС" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Б.ЦЭНД-АЮУШ

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ
№ХА/2025/08

2025 оны 02-р сарын 03-ний өдөр Чойбалсан хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нэг талаас "ДБЭХС" ТӨХК /цаашид "Худалдан авагч" гэх/, нөгөө талаас "Баян баядын залуус" ХХК /цаашид "Худалдагч" хамтад нь "Талууд" гэх/ Монгол улсын Иргэний Хуулийн 243-261 зүйлүүдийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2025 оны 02 дугаар сарын 03-ний өдөр энэхүү гэрээг байгуулав.

1.2. Гэрээний нөхцөлийн дагуу худалдагч нь биет байдлын болон эрхийн доголдолгүй **Үйлдвэрийн суурин компрессор 22кВ** үйлдвэрийн бүтээгдэхүүнийг /цаашид "Бүтээгдэхүүн" гэх/ худалдан авагчид шилжүүлэх ба худалдан авагч нь бүтээгдэхүүний төлбөрийг гэрээний дагуу худалдагчид дансаар шилжүүлнэ.

1.3. Худалдагчийн бүтээгдэхүүн нь олон улсын болон Монгол улсын стандартын шаардлага, худалдан авагчийн техникийн нөхцөлийг хангасан байна.

1.4. Бүтээгдэхүүн нь стандартад нийцсэн сав, баглаатай байна.

Хоёр. Худалдан авагчийн эрх, үүрэг

2.1. Худалдагчаас бүтээгдэхүүн шилжүүлэх хугацааг мэдэгдсэнээс хойшхи ажлын 2 хоногийн дотор бүтээгдэхүүнийг хүлээж авна.

2.2. Худалдан авагч бүтээгдэхүүнийг хүлээн авахдаа худалдагчийг байлцуулан холбогдох алба хэлтсийн ажилтан болон хангамжийн мэргэжилтэн, агуулахын нярав нар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

а/ Захиалгаар нийлүүлэх нэр төрөл, тоо хэмжээгээр тоолж шалгаж хүлээж авна.

2.3. Хэрвээ бүтээгдэхүүнийг хүлээж авах явцад доголдол илэрсэн нөхцөлд худалдагчид албан бичгээр мэдэгдэж, бүтээгдэхүүнийг хүлээж авахаас татгалзана.

2.5. Худалдан авагч бүтээгдэхүүний гэмтэл, доголдлын талаар акт үйлдсэн байна.

Гурав. Худалдагчийн эрх, үүрэг

3.1. Худалдагч тал бүтээгдэхүүнийг Хавсралт 1-т заасан нэр төрлийн ... хугацаанд багтааж худалдан авагч талд шилжүүлнэ.



6.4. Энэхүү гэрээний үйлчлэх хугацаанд хүлээсэн үүргээ биелүүлэхээс нэг тал үндэслэлгүйгээр татгалзсан бол буруутай тал нөгөө талдаа үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх торгууль төлнө.

6.5. Торгууль төлсөн, хохирлыг барагдуулсан нь гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Долоо. Авилгийн эсрэг заалт

7.1. Талууд энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан мөнгөн буюу мөнгөн бус хэлбэрээр шагнал, шан харамж, урамшуулал зэрэг гэрээнд тусгагдаагүй аливаа төлбөрийг харилцан төлөөгүй болно.

7.2. Нийлүүлэгч тал нь энэхүү гэрээнд заасан ажил үүрэг гүйцэтгэхдээ Захиалагч талын удирдлагын баг болон ажилтан холбогдох албан тушаалтанд мэдэгдэхгүйгээр хувьд нь хөнгөлөлттэй ажил үйлчилгээ амлах, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөхийг хориглоно. Хэрэв үүнээс үүдэн Захиалагч болон гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

7.3. Захиалагч нь Нийлүүлэгч талын удирдлагын баг болон ажилтнаас энэхүү гэрээний ажил үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан хөнгөлөлттэй ажил үйлчилгээ, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөхийг шаардсан тохиолдолд үүнийг үйлчлүүлэгч талын эрх бүхий албан тушаалтанд мэдээлэх үүрэгтэй.

Найм. Давагдашгүй хүчин зүйл

8.1. Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

8.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

8.3. Тухайн нөхцөл байдлын улмаас гэрээний үүргийн хугацаа 15 хоногоор хойшлогдвол талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлэхээс татгалзаж болно. Энэ тохиолдолд хохирол төлүүлэхийг шаардахгүй.

8.4. Онцгой нөхцөл үүссэн үед болон гэрээнд заасан бусад нөхцлүүдийн үед гэрээг сунгана.





Хавсралт 4

“Авлигын эсрэг хамтдаа” мэдээллийн самбар болон контентийг харуулсан байдал




